



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 1144

Арвайхээр

Г Коронавируст халдварт (Ковид-19)-ын цар тахлын тархалттай холбогдуулан авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “б”, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8, 32.1.9 дэх заалт, Улсын Онцгой комиссын 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар хурал, аймгийн Онцгой комиссын 2021 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 17 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдварт (Ковид-19)-ын цар тахлын батлагдсан тохиолдол илэрсэнтэй холбогдуулан хариу арга хэмжээг авч, урьдчилан сэргийлэх, эрсдээлийг бууруулах зорилгоор Арвайхээр, Бат-Өлзий, Хархорин, Хужирт, Бүрд сумдын төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг 2021 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд гамшигаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын Улаан түвшинд, бусад сумдыг гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын Улбар шар түвшинд шилжүүлсүгэй.

2. Гамшигаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын Улаан түвшинд шилжсэнтэй холбогдуулан Арвайхээр, Бат-Өлзий, Хархорин, Хужирт, Бүрд сумдад хавсралтад зааснаас бусад бүх төрлийн үйл ажиллагааг 2021 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 06:00 цаг хүртэл хориглосугай.

3. Арвайхээр суманд үйл ажиллагаа явуулж байгаа томоохон худалдааны төвүүдийн (Номин, Арцат, Молор, Арвин) ажиллах цагийн хуваарийг тогтоож, гэр хорооллын дэлгүүрүүдэд хүнсний бөөний түгээлт хийлгэж ажиллахыг Арвайхээр сумын Засаг дарга (Б.Ганбат)-д даалгасугай.

4. Гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын Улбар шар түвшинд шилжүүлсэн сумдад түргэвчилсэн оношлуураар тандалтын шинжилгээ хийж, Коронавируст халдварт (Ковид-19)-ын тархалтын түвшин тогтоох, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах түр журмын дагуу холбогдох хязгаарлалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Хүнсний худалдаа, эмийн сан, уст цэг, шатахуун түгээх станцын үйл ажиллагаа явуулж буй иргэн, байгууллагуудад бүртгэл хяналтын системийг тогтмол хөтлүүлж, эрүүл ахуй, халдварт хамгааллын дэглэм, ариутгал халдвартайжүүлэлтэд хяналт тавьж, зөрчил гаргасан газруудын үйл ажиллагааг нэн даруй зогсоох арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн 011100318